



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангайн нурууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/36/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитор Н.Энхчимэг Утас: 703333019 Цахим хаяг: Enkhchimeg@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	17
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХНБЦГХЗ	Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуучлалын яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуучлалын газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ХАНГАЙН НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Г.ГАНБОЛД ТАНАА

2022.02.17 № 15
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангайн нурууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангайн нурууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	54,055,953.29	52,095,895.70
33	АВЛАГА	34,570.32	0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	34,570.32	0
35	БАРАА МАТЕРИАЛ	54,021,382.97	52,095,895.70
35400	Хангамжийн материал	54,021,382.97	52,095,895.70
35410	Бичиг хэргийн материал	6,431,835.00	1,277,945.68
35420	Аж ахуйн материал	22,023,447.97	20,142,250.02
35430	Сэлбэг хэрэгсэл	408,100.00	0
35470	Бусад хангамжийн материал	25,158,000.00	30,675,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,399,260,071.67	1,572,290,760.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,399,260,071.67	1,572,290,760.48
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	1,392,155,871.67	1,565,434,060.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,168,445,913.00	1,168,445,913.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-63,370,693.52	-102,227,377.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	206,630,036.32	279,640,365.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	-126,414,626.76	-86,715,910.87
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	56,747,911.96	53,168,847.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,119,439.30	-33,643,066.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	129,075,467.43	128,099,267.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,980,092.32	-32,736,189.45
39214	Бусад үндсэн хөрөнгө	102,974,655.30	243,845,452.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-32,833,260.44	-52,443,241.25
39300	Биет бус хөрөнгө	7,104,200.00	6,856,700.00
39301	Програм хангамж	495,000.00	495,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0	-247,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,609,200.00	6,609,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,453,316,024.96	1,624,386,656.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,453,316,024.96	1,624,386,656.18
51	Засгийн газрын хувь оролцоо	1,453,316,024.96	1,624,386,656.18
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	134,172,451.17	0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	134,172,451.17
51200	Хуримтлагдсан үр дүн	1,144,094,270.07	1,315,164,901.29
51210	Өмнөх үеийн үр дүн	1,118,026,346.29	1,144,094,270.07
51220	Тайлант үеийн үр дүн	26,067,923.78	171,070,631.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	175,049,303.72	175,049,303.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,453,316,024.96	1,624,386,656.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	503,005,841.00	691,125,375.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	125,815,741.00	271,549,775.00
120	Нийтлэг татварын бус орлого	125,815,741.00	271,549,775.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,627,000.00	23,410,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,627,000.00	23,410,600.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	114,667,931.00	244,529,557.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,520,810.00	3,609,618.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	377,190,100.00	419,575,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	366,485,200.00	413,075,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	366,485,200.00	413,075,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,704,900.00	6,500,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,050,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,654,900.00	6,500,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	476,937,917.22	520,054,743.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,937,917.22	520,054,743.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	460,326,327.73	462,309,520.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,733,427.51	199,240,827.00
210101	Үндсэн цалин	145,851,290.06	156,904,574.00
210102	Нэмэгдэл	34,073,751.85	32,893,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,677,428.60	9,442,753.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,130,957.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,022,755.01	25,587,634.06
210201	Тэтгэврийн даатгал	17,217,990.67	18,122,445.43
210202	Тэтгэмжийн даатгал	2,012,491.94	2,013,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,609,998.99	1,599,828.88
210204	Ажилгүйдлийн даатгал	381,222.08	350,205.57
210205	Эрүүл мэндийн даатгал	3,801,051.33	3,502,054.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,545,451.62	30,188,497.18
210301	Гэрэл, цахилгаан	1,076,300.54	1,022,207.48
210302	Түлш, халаалт	30,049,408.00	27,353,908.00
210303	Цэвэр, бохир ус	419,743.08	1,812,381.70
2104	Хангамж, бараа материалын зардал	18,367,212.75	11,830,807.00
210401	Бичиг хэрэг	1,265,600.00	600,660.00
210402	Тээвэр, шатахуун	13,919,700.00	9,110,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,380,042.19	1,096,357.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	428,600.00	627,790.00
210408	Бараа материал акталсны зардал	1,373,270.56	396,000.00
2105	Нормативт зардал	293,000.00	293,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	293,000.00	293,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,765,500.00	5,058,600.00
210604	Урсгал засвар	1,765,500.00	5,058,600.00
2107	Томилолт, зочны зардал	3,053,500.00	2,607,500.00
210702	Дотоод албан томилолт	3,053,500.00	2,607,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,156,945.43	75,316,206.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,670,977.43	74,636,794.95
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	143,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	656,368.00	202,392.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,300.00	64,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	475,500.00	249,120.00

Архангай аймгийн ХНБЦГХЗ-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,388,535.41	112,186,448.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	460,500.00	197,580.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,928,035.41	111,988,868.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,611,589.49	57,745,223.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,509,101.00	37,052,486.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,909,101.00	37,052,486.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,102,488.49	20,692,737.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,096,738.49	20,687,017.40
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,750.00	5,720.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	26,067,923.78	171,070,631.22
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	26,067,923.78	171,070,631.22

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,172,451.17	176,301,468.94	1,116,674,118.50	1,427,148,038.61
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,352,227.79	1,352,227.79
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,172,451.17	176,301,468.94	1,118,026,346.29	1,428,500,266.40
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-1,252,165.22	0	-1,252,165.22
9	Тайлант үеийн үр дүн	0	0	26,067,923.78	26,067,923.78
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,172,451.17	175,049,303.72	1,144,094,270.07	1,453,316,024.96
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	134,172,451.17	175,049,303.72	1,144,094,270.07	1,453,316,024.96
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,172,451.17	175,049,303.72	1,144,094,270.07	1,453,316,024.96
19	Тайлант үеийн үр дүн	0	0	171,070,631.22	171,070,631.22
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	134,172,451.17	175,049,303.72	1,315,164,901.29	1,624,386,656.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	386,847,939.00	444,543,618.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,657,839.00	24,968,018.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,657,839.00	24,968,018.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,657,839.00	24,968,018.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,657,839.00	24,968,018.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	377,190,100.00	419,575,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	366,485,200.00	413,075,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	366,485,200.00	413,075,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,704,900.00	6,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,704,900.00	6,500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	367,047,939.00	404,053,618.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	367,047,939.00	404,053,618.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	350,436,349.51	346,308,394.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,733,427.51	200,798,245.00
210101	Үндсэн цалин	145,851,290.06	158,461,992.00
210102	Нэмэгдэл	34,073,751.85	32,893,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,677,428.60	9,442,753.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,130,957.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,022,755.01	25,587,634.06
210201	Тэтгэврийн даатгал	17,217,990.67	18,122,445.43
210202	Тэтгэмжийн даатгал	2,012,491.94	2,013,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,609,998.99	1,599,828.88
210204	Ажилгүйдлийн даатгал	381,222.08	350,205.57
210205	Эрүүл мэндийн даатгал	3,801,051.33	3,502,054.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,545,451.62	30,188,497.18
210301	Гэрэл, цахилгаан	1,076,300.54	1,430,098.48
210302	Түлш, халаалт	30,049,408.00	26,775,400.00
210303	Цэвэр, бохир ус	419,743.08	1,982,998.70
2104	Хангамж, бараа материалын зардал	18,594,412.19	11,379,497.00
210401	Бичиг хэрэг	1,375,463.00	472,600.00
210402	Тээвэр, шатахуун	14,993,450.00	9,298,397.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,387,079.19	1,477,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	838,420.00	130,900.00
2105	Нормативт зардал	293,000.00	293,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	293,000.00	293,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,290,100.00	1,681,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	202,000.00	161,000.00
210604	Урсгал засвар	5,088,100.00	1,520,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,053,500.00	2,607,500.00
210702	Дотоод албан томилолт	3,053,500.00	2,607,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,443,203.18	73,575,921.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,957,235.18	72,891,649.36
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	143,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	656,368.00	207,252.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,300.00	64,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	475,500.00	249,120.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	460,500.00	197,100.00

Архангай аймгийн ХНБЦГХЗ-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	460,500.00	197,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,611,589.49	57,745,223.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,509,101.00	37,052,486.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,909,101.00	37,052,486.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,102,488.49	20,692,737.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,096,738.49	20,687,017.40
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,750.00	5,720.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,800,000.00	40,490,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,800,000.00	40,490,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,800,000.00	40,490,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,800,000.00	40,490,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,800,000.00	40,490,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-19,800,000.00	-40,490,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	421,575,600.00	417,356,600.60	4,218,999.40	99.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,575,600.00	417,356,600.60	4,218,999.40	99.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,499,700.00	380,304,114.60	4,195,585.40	98.9%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,309,800.00	200,798,245.00	511,555.00	99.7%
210101	Үндсэн цалин	158,462,300.00	158,461,992.00	308.00	100.0%
210102	Нэмэгдэл	32,893,500.00	32,893,500.00	0.00	100.0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,954,000.00	9,442,753.00	511,247.00	94.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,176,800.00	25,587,634.06	1,589,165.94	94.2%
210201	Тэтгэврийн даатгал	19,124,400.00	18,122,445.43	1,001,954.57	94.8%
210202	Тэтгэмжийн даатгал	2,013,100.00	2,013,100.00	0.00	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,610,500.00	1,599,828.88	10,671.12	99.3%
210204	Ажилгүйдлийн даатгал	402,600.00	350,205.57	52,394.43	87.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,026,200.00	3,502,054.18	524,145.82	87.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,205,100.00	30,188,497.18	16,602.82	99.9%
210301	Гэрэл, цахилгаан	1,430,100.00	1,430,098.48	1.52	100.0%
210302	Түлш, халаалт	26,775,400.00	26,775,400.00	0.00	100.0%
210303	Цэвэр, бохир ус	1,999,600.00	1,982,998.70	16,601.30	99.2%
2104	Хангамж, бараа материалын зардал	10,669,500.00	10,669,497.00	3.00	100.0%
210401	Бичиг хэрэг	472,600.00	472,600.00	0.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	8,588,400.00	8,588,397.00	3.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,477,600.00	1,477,600.00	0.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	130,900.00	130,900.00	0.00	100.0%
2105	Нормативт зардал	293,000.00	293,000.00	0.00	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	293,000.00	293,000.00	0.00	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,688,600.00	1,681,000.00	7,600.00	99.5%
210601	Багаж, техник, хэрэгсэл	161,600.00	161,000.00	600.00	99.6%
210604	Урсгал засвар	1,527,000.00	1,520,000.00	7,000.00	99.5%
2107	Томилолт, зочны зардал	2,186,200.00	2,182,000.00	4,200.00	99.8%
210702	Дотоод албан томилолт	2,186,200.00	2,182,000.00	4,200.00	99.8%
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0	0.00	98.1%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,773,200.00	108,707,141.36	2,066,058.64	98.1%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,080,700.00	108,022,869.36	2,057,830.64	98.1%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	143,800.00	4,700.00	96.8%
210803	Даатгалын үйлчилгээ	209,900.00	207,252.00	2,648.00	98.7%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,300.00	64,300.00	0.00	100.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00	0.00	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	249,120.00	880.00	99.6%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,500.00	197,100.00	400.00	99.8%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	197,500.00	197,100.00	400.00	99.8%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,075,900.00	37,052,486.00	23,414.00	99.9%
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,075,900.00	37,052,486.00	23,414.00	99.9%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,075,900.00	37,052,486.00	23,414.00	99.9%

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	421,575,600.00	417,356,600.60	4,218,999.40	99.0%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	413,075,600.00	392,388,582.60	20,687,017.40	95.0%
310001	Улсын төсвөөс санхүүжих	413,075,600.00	392,388,582.60	20,687,017.40	95.0%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,500,000.00	24,968,018.00	16,468,018.00	293.7%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,500,000.00	24,968,018.00	16,468,018.00	293.7%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	41	41	0.00	100.0%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0%
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	0.00	100.0%
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	20	0.00	100.0%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15	15	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,494,280.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,494,280.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,494,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	710,000.00
210402	Тээвэр, шатахуун	710,000.00
2107	Томилот, зочны зардал	425,000.00
210702	Дотоод албан томилот	425,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,325,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,325,780.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,494,280.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,494,280.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,494,280.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ХНБЦГХЗ-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Энхчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

ХНБЦГХЗ-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ХНБЦГХЗ нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27.1-д заасны дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын багцын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Байгаль орчин, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийг иргэдэд ил тод хүртээмжтэйгээр хүргэх, ойн зөрчил, Хууль бус ан агнуурыг багасгах замаар биологийн төрөл зүйлийн тоог нэмэгдүүлэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мөрддөг хууль, журамд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй” гэснээр даатгуулагч болон ажил олгогчоос төлөх НДШ тус бүр 1%-аар буурч өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэлээ. Дотоод хяналтын ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулсан байна. Харин дотоод хяналтыг зөвхөн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хийж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй, дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр дүн хангалтгүй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Хангайн нурууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 421.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1,453.3 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар өссөн бөгөөд материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Авлага	0.03	0.0	(0.03)	(100)
Бараа материал	54.0	52.1	-1.9	-3.5
Үндсэн хөрөнгө	1,399.3	1,572.3	173.0	12.4
Нийт хөрөнгө	1,453.3	1,624.4	171.1	11.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,453.3	1,624.4	171.1	11.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,453.3	1,624.4	171.1	11.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын эхний үлдэгдэл өмнөх оноос 100 хувиар буурсан байна.
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 3.5 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 54.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 40.0 төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 4.7 сая төгрөг нийт 44.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 46.6 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 52.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлээс оноос 11.8 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,399.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 40.5 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 227.5 сая, үнийн зөрүүнээс нэмэгдсэн 17.0 сая, нийт 285.0 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн бол 8.5 сая төгрөгийн хөрөнгийг актлаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 67.2 сая төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлэхийн тулд хассан, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 36.3 сая төгрөг нийт 112.0 сая төгрөгөөр буурч 1,572.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 171.1 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төг/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	366.5	413.1	46.6
Үндсэн үйл ажиллагааны орлого	9.6	23.4	13.8
Нэмэлт санхүүжилтийн орлого	10.7	6.5	(4.2)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	114.7	244.5	129.8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1.5	3.6	2.1
Үйл ажиллагааны орлого	503.0	691.1	188.1
Цалин, шимтгэлийн зардал	227.7	224.8	(2.9)
Бусад бараа үйлчилгээний зардал	55.0	48.9	(6.1)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64.2	75.3	11.1
Бараа үйлчилгээний бусад зардал	113.4	112.2	(1.2)
Урсгал шилжүүлэг	16.6	57.7	41.1
Хөрөнгө шилжүүлсэн			-
Үйл ажиллагааны зардал	476.90	518.9	42.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	26.10	172.20	146.1

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 46.6 сая төгрөг буюу 1.1 хувиар өссөн нь санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 46.6 сая төгрөгөөр буурсан байна. Харин үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 214.6 хувиар өссөн нь Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудыг орлогод авч, бүртгэж тайлагнасантай холбоотой байна. Урсгал санхүүжилтээс 10.0 сая төгрөг хэмнэгдэж буцаан төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 416.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 0.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 416.4 сая төгрөгөөр хянасан бөгөөд 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн төсвийн тодотголоор 5.2 сая төгрөгөөр дахин нэмэгдүүлж 421.6 сая төгрөг болгож батлуулсан байна.

Төсвийг нэмэгдүүлсэн шалтгаан нь био ариун цэврийн байгууламж барих зорилгоор бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд улсын төсвөөс 413.1 сая төгрөгийн, төсөвт байгууллагын өөрийн орлого 24.9 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 6.5 сая, төгрөг нийт 444.5 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 423.8 сая төгрөг зарцуулж 20.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Энэ нь үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос 16.5 сая төгрөг, бараа үйлчилгээний урсгал зардлуудын хэмнэлт 4.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн БОАЖГ-аас биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх ажлын хөлс 5.0 сая, ойн цэвэрлэгээний төлбөр 0.9 сая төгрөгийн санхүүжилт авч, тусгай хамгаалалтай газар нутагт газар ашиглах гэрээнд заасан 0.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж нийт 6.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд тус байгууллагын нягтлан бодогч Д.Энх-Амгалан нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч ажлаас чөлөөлөгдсөн боловч ХНБЦГХЗ-ны даргын 2021.11.15-ны өдрийн б/11 дугаар тушаалаар түр томилогдон ажиллаж байна.

3.8 Аудитын гол асуудал

- Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 89.0 хувь байна.

- Тайлант онд хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан нийт 421.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 417.4 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 99.0 хувь байна.

- Тус байгууллага нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасны дагуу төсөвт байгууллагын өөрийн орлогыг 10.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 23.4 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 53.7 хувиар давуулан биелүүлжээ. Энэ нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлыг нөхөн төлүүлсэн 13.2 сая төгрөгийн төлбөрийн орлоготой холбоотой байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

Байгууллагын нягтлан бодогч, сахиул нар өндөр насны тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдсөн боловч нөхөн томилгоо хийж, 3.6 сая төгрөгийн цалин олгосон байна.

Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2.Суудлын автомашин ашиглалтын хувьд: Ланд-76 маркийн 2017 онд үйлдвэрлэгдсэн 38.5 сая төгрөг, УАЗ-3909 маркийн 2017 онд үйлдвэрлэгдсэн 93.2 сая төгрөгийн анхны өртөг бүхий автомашинуудтай бөгөөд шатахууны зардалд 9.3 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 8.5 сая төгрөгийг олгожээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байдаг.

Энэ санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгасан үр дүнг доор харууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

ХНБЦГХЗ нь 2021 онд нийт 59.4 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээллэсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгалаа. Хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Хамгаалалтын захиргааны ажилтан албан хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, 2022 оны үйл ажиллагааны үндсэн зорилтуудыг тодорхойлох, байгаль хамгаалагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах сургалт зохион байгуулж 0.8 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитын талаар:

Тус байгууллагын 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд дараах зөрчил илэрсэн.

1. Бусдаар гүйцэтгүүлэхээр гэрээлсэн ажлыг хугацаанд нь гүйцэтгүүлээгүй, явцын хяналт хийхээр гэрээнд тусгасан боловч хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлж аудитын явцад гэрээнд заасан ажлыг бүрэн гүйцэтгүүлж биелэлтийг хангууллаа.

2. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах тайлагнах журам”-д заасан урьдчилгаа санхүүжилт 30%-иас ихгүй байна гэсэн заалтыг зөрчиж санхүүжилт олгосон зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг хангуулаад байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул аудитаас зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар БОАЖС-ын тушаалын дагуу бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэж байгаа болон төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх, газар ашиглах гэрээнд заасан төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн эсэхийг авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 2 албан шаардлагыг хүргүүллээ.

4.1. Албан шаардлага

- Хорго-Тэрхийн цагаан нуурын цогцолборт тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа эрх бүхий 4 иргэн, ААНэгжийн газар ашиглах гэрээг БОАЖСайдын 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/378 дугаар тушаалаар баталсан маягтаар шинэчилж байгуулаагүй байна.

Энэ нь БОАЖС-ын 2018 оны А/378 дугаар тушаал “Журмын хавсралтад өөрчлөлт оруулах, газар ашиглах эрхтэй холбоотой өргөдлийн маягтыг шинээр батлах тухай тушаал” ын 3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: БОАЖС-ын 2018 оны А/378 дугаар тушаалыг мөрдөн газар ашиглах гэрээг шинэчлэн байгуулах албан шаардлага өгөх.

4.2. Төлбөрийн акт

- БОАЖЯ-аас Хорго-Тэрхийн цагаан нуурын цогцолборт нутагт газар ашиглах эрх олгосон 4 иргэн, 1 ААН-тэй БОАЖС-ын 2018 оны А/378 дугаар тушаалын дагуу гэрээг шинэчлэн байгуулсан. Уг гэрээний 3.8-д “Аялалын маршрутын дагуу стандартад нийцсэн нийтийн ариун цэврийн байгууламж, хогийн цэг барих” хөрөнгийн зардалд 5 жилийн хугацаанд 3.0 сая төгрөг, жилд 0.6 сая төгрөг төвлөрүүлэх гэж тусгасан боловч 2021 онд нийт 2.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь ХНБЦГХЗ-ны дарга, Сумын засаг дарга, иргэн, ААНэгжтэй байгуулсан гурвалсан гэрээний 3.8 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	ХНБЦГХЗ	2	2.4	0	0	1	2.4	1	0	0	0
	Дүн	2	2.4			1	2.4	1			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	ХНБЦГХЗ	1	0.8	0	0			1	0.8	0	0
	Дүн	1	0.8	0	0			1	0.8	0	0
	Нийт дүн	3	3.2			1	2.4	2	0.8		

